

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 02 дугаар сарын 07

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2021 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд гадаадын 1027 иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 738 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 289 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад илгээлээ. (Хүснэгт 1, График 1)

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн гадаадын 74 иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз, 3 иргэнд визийн шилжүүлэг, 17 иргэнд гарах-орох цагаачийн мэдэгдэл олгосон. (Хүснэгт 1, График 1)

Хүснэгт 1

Визийн зөвшөөрөл		Виз	Оршин суух зөвшөөрөл			Түр ирэгч	
Хилийн чанадад	Хилийн боомтод		олгосон	сунгасан	хэлбэр, төрөл өөрчилсөн	хаягийн бүртгэл	байх хугацаа сунгалт
738	289	74	695	4627	4	267	144
1027							

2022 оны 01 дүгээр сард нийт 300 аж ахуйн нэгж, байгууллагын 757 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ.

“evisa.mn” цахим системээр нийт 14 улсын 59 иргэнд цахим виз олгож, 2 улсын 2 иргэний визийн хүсэлтэд татгалзсан.


1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн гадаадын 695 иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 4627 иргэний оршин суух зөвшөөрлийн

хугацааг сунгасан. Оршин суугаа хэлбэр нь өөрчлөгдсөн 4 иргэнд оршин суух хэлбэр солих үйлчилгээ үзүүлсэн байна. (Хүснэгт 1, График 1)

Гадаадын иргэнийг уригч 44 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу гадаадын 77 иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн гадаадын 267 иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэлээ. Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 144 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. (Хүснэгт 1)

График 1



Дээрх тоон үзүүлэлтийг 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 256 дахин өсөж, виз олголт 93,1 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 11,6 хувь, оршин суух зөвшөөрлийн сунгалт 17,0 хувиар тус тус буурчээ.

Цахим хэлбэртэй “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 3563 ширхэг шинээр хэвлэж, 1811 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 37 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрөл авах болон оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн гадаадын 150 иргэний хүсэлтийг байгууллагын даргын 3 удаагийн тушаалаар шийдвэрлэж, гадаадын 12 иргэнд регистрийн дугаар, 1 иргэнд зорчих үнэмлэх олгов.

1.1.3. Зөвлөгөө, мэдээлэл:

Тайлант хугацаанд гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн хаягийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 1822 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

- Биечлэн – 109;
- 1800-1882 дугаарын утас – 1347;

- Фэйсбүүк хуудас чат – 189;
- Автомат хариулагч – 142;
- Имэйл – 35.

Код мессеж үйлчилгээг 267 иргэнд хүргэж, гадаадын 58 иргэнд паспорт, 1740 иргэнд оршин суух үнэмлэхийг буцаан олголоо.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Монгол Улсын харьяат болох:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан Оросын Холбооны Улсын 1 иргэний хүсэлт, баримт бичигт холбогдох байгууллагуудаас санал авч, дүгнэлт үйлдэн Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг Эрхлэх газарт хүргүүлсэн.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан Оросын Холбооны улсын 1 иргэний хүсэлт, баримт бичигт ирүүлсэн санал, дүгнэлтийг Ерөнхий сайдад танилцуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан Оросын холбооны Улсын 1 иргэний хүсэлт Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-т заасан “амьжиргааны зохих чадвар, эх үүсвэртэй байх” шалгуурыг хангаагүй тул мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1-т заасны дагуу, Румын Улсын 1 иргэний хүсэлт баримт бичиг Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шалгуурыг хангаагүй тул мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу тус тус хүсэлтийг түдгэлзүүлсэн.

1.2.2. Монгол Улсын харьяатаас гарах:

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын (Бүгд Найрамдах Австри Улсын 1, Бүгд Найрамдах Казахстан Улсын 2, Бүгд Найрамдах Солонгос Улсын 3, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 9, Япон Улсын 5) харьяат болох хүсэлт гаргасан нийт 20 иргэний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авсан.

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын (Бүгд Найрамдах Сингапур Улсын 2, Бүгд Найрамдах Солонгос Улсын 3, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 10, Япон Улсын 5) харьяат болох хүсэлт гаргасан нийт 20 иргэний хүсэлт, баримт бичигт холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг явууллаа.

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын (Бүгд Найрамдах Австри Улсын 1, Бүгд Найрамдах Солонгос Улсын 3, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 6, Япон Улсын 1) харьяат болох хүсэлт гаргасан нийт 11 иргэний хүсэлт, баримт бичигт холбогдох байгууллагуудаас санал авч, дүгнэлт үйлдэн Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Монгол Улсын харьяатаас гарч бусад улсын (Бүгд Найрамдах Австри Улсын 1, Бүгд Найрамдах Казахстан Улсын 10, Бүгд Найрамдах Солонгос Улсын 3, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 9, Япон Улсын 1) харьяат болох хүсэлт гаргасан нийт 24 иргэний хүсэлт, баримт бичигт холбогдох байгууллагуудаас санал авч, дүгнэлт үйлдэн Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.

1.2.3. Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох:

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй 1 хүний хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, мөн хүсэлт гаргасан харьяалалгүй 3 хүний хүсэлт, баримт бичигт холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг явууллаа.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй 1 хүний хүсэлт, баримт бичигт холбогдох байгууллагуудаас санал авч, дүгнэлт үйлдэн Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг Эрхлэх газарт, хүсэлт гаргасан харьяалалгүй 2 хүний хүсэлт, баримт бичигт холбогдох байгууллагуудаас санал авч, дүгнэлт үйлдэн Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Хүснэгт 2

Он, сар, өдөр	Монгол Улсын харьяат болсон	Иргэний харьяаллыг сэргээн тогтоосон	Монгол Улсын харьяатаас гарсан	Хүлээж авсан материал	Хоёрдмол харьяалалтай иргэнийг бүртгэсэн
2021.12.11-2022.01.31	-	-	-	18	32
Өссөн дүнгээр	-	-	-	18	32

Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор 52 улсын 3944 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 32 иргэнийг шинээр бүртгэжээ. (Хүснэгт 2)

Мөн хоёрдмол харьяалал үүсгэсэн 20 иргэний зөрчлийг шийдвэрлэж, “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-аас хасалт хийлээ.

1.2.4. Хүүхэд үрчлэлт:

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Итали Улсын гэр бүлтэй 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдөр ярилцлага зохион байгуулж, 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр байгууллагын “Мэргэжлийн зөвлөлийн хурал”-аар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн.

Байгууллагын даргын 2022 оны А/02 дугаар тушаалаар Монгол Улсын харьяат 1 хүүхдийг Бүгд Найрамдах Итали Улсын гэр бүлд үрчлүүлж, 01 дүгээр сарын 06-ны өдөр үрчлэлтийн дараа хяналт тавих 3 талт гэрээг байгуулав.

Гадаадын иргэн, гэр бүл (Америкийн Нэгдсэн Улсын гэр бүлд үрчлэгдсэн 6, Бүгд Найрамдах Итали Улсын гэр бүлд үрчлэгдсэн 2)-д үрчлэгдсэн нийт 8 хүүхдийн тайланг хүлээн авч, мэдээллийн санд бүртгэсэн.

1.2.5. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаатай холбоотой 14 байгууллагын санал (зөвшөөрлийн хугацааг сунгуулах 14)-ыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Байгууллагын “Мэргэжлийн зөвлөл”-ийн 2 удаагийн хурлаар хүсэлт ирүүлсэн нийт 18 олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлт (зөвшөөрлийн хугацааг сунгуулах 16, зөвшөөрлийг хүчингүй болгох 2)-ийг хэлэлцүүлж, шийдвэрлэв.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/04 дүгээр, 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/88 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Байгууллагын “Хяналт шалгалтын 2022 оны төлөвлөгөө”-г баталж, гадаадын 80 иргэний паспорт, түүнийг орлох баримт бичигт явуулсан 2 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалтаар Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг зөрчсөн 1 зөрчлийг илрүүлэн, харьяаллын дагуу шилжүүллээ.

Төлөвлөгөөт бус 32 удаагийн хяналт шалгалтаар 34 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 193 иргэнийг хамруулан, оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтрүүлсэн 1, паспорт, түүнийг орлох баримт бичгийг биедээ авч яваагүй 71 зөрчлийг илрүүлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн.

01 дүгээр сард төлөвлөгөөт 2, төлөвлөгөөт бус 32 (удирдамжийн дагуу 22, өргөдөл гомдлын дагуу 5, гомдол мэдээллийн дагуу 5) нийт 34 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, 34 аж ахуйн нэгж, байгууллага гадаадын 273 иргэнийг хамруулсан байна.

Тайлант хугацаанд нийт 14 улсын 92 гадаадын иргэн, 1 уригч иргэн (1 иргэн)-д Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн дагуу нийт 19,200,000 төгрөг (Арван есөн сая хоёр зуун мянган)-ийн торгох шийтгэл оногдууллаа. (*График 3*)

1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.11, 37.1.12 дахь заалтууд (оршин суух зөвшөөрлийн хугацаа нь дууссан боловч Монгол Улсаас гарч явахаас зайлсхийсэн, шүүхээр ял шийтгүүлсэн гадаадын иргэн ялаа эдэлж дууссан буюу ялаас чөлөөлөгдсөн, эсхүл тухайн гадаадын иргэнийг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу харьяалах улсад нь шилжүүлэхээр болсон, түр ирэгч визийн хугацааг хэтрүүлсэн)-ыг тус тус үндэслэн 4 улсын 4 гадаадын иргэнийг байгууллагын даргын 4 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргах шийдвэр гаргалаа. (*Хүснэгт 3, График 3*)

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 8 иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсын 1 иргэнийг гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгож, хилээр нэвтрэх эрхийг сэргээсэн.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын 1 иргэний оршин суух зөвшөөрлийг цуцалж, гарах сануулга өгөв.

Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний мэдээ

Хүснэгт 3

№	Улс	Зүйлчлэл			Нийт
		37.1.2	37.1.11	37.1.12	
1	Вьетнам	1			1
2	Конго			1	1
3	Нигери			1	1
4	Пакистан		1		1
Бүгд		1	1	2	4

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан үндэслэлээр Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 1 удаагийн захирамжаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэнийг саатуулж, уг иргэний саатуулсан хугацааг 30 хоногоор сунгажээ.

Хойд бүс дэх газар Монгол Улсад виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн 2 улсын 3 иргэн, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын түргэвчилсэн шинжилгээгээр эерэг гарсан 2 улсын 2 иргэн, Агаарын замын боомт хариуцсан газар орох виз, визийн зөвшөөрөлгүй, ирсэн зорилгоо тодорхойлж чадаагүй Бүгд Найрамдах Солонгос Улсын 1 иргэнийг хилээр нэвтрүүлэлгүй буцааж, Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсын 1 иргэнийг хилээр гаргалгүй буцаасан.

График 3



2022 оны 01 дүгээр сарын тоон үзүүлэлтийг 2021 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 8,4 дахин, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 2,7 дахин өсөж, албадан гаргагдсан гадаадын иргэн 42,9 хувь буурсан бол зөрчил гаргасан уригч иргэн 1 бүртгэгдэж, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд бүртгэгдээгүй байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн холбогдох арга хэмжээний 2021 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлсэн тайланг 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 01/82 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яам, 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/218 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлсэн. Хууль тогтоомжийн 26 заалтын хэрэгжилт 100 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний холбогдох арга хэмжээний 4 заалтын хэрэгжилт 92,5 хувьтай үнэлэгдсэн байна.

“Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулга, үзэл баримтлалын хамт 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/1730 дугаар, Гадаадын хөрөнгө оруулагч иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга, шийдвэрлэлтийн талаарх тайланг 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/181 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт тус тус хүргүүллээ.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2021 оны хэрэгжилтэд хяналт- шинжилгээ хийж, үнэлсэн тайланг 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01/122 дугаар, “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”, “Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн 2021 оны тайланг 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/198 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын холбогдох заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, тайланг 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01/205 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд хүргүүлэв.

Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоол батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Залуучуудын хөгжлийн хөтөлбөр”-ийн байгууллагад холбогдох зорилт, арга хэмжээний 2021 оны хэрэгжилтийг 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/02 дугаар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/47 дүгээр тушаалаар батлагдсан “Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний биелэлтийг 12 дугаар сарын 24-ний өдрийн 01/81 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу холбогдох хэсгийн 2021 оны 4 дүгээр улирлын танилцуулах мэдээг 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/20 дугаар, “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10,0 их наядын цогц төлөвлөгөө”-ний 2021 оны хэрэгжилтийг 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/106 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 12 дугаар сарын 15-ны өдрийн 01/21 дүгээр, Байгууллагын 12 дугаар сарын тайланг тоон мэдээ (инфографик) хэлбэрээр 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/69 дүгээр, байгууллагын жилийн эцсийн тайланг мөн өдрийн 01/70 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр байгууллагын цахим хуудаст байршуулан олон нийтэд нээлттэй мэдээлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/145 дугаар, 2021 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн тайланг 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01/123 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд мөн хүргүүлсэн.

Төрийн мэдээллийн сүлжээ [/mojha.unelgee.gov.mn/](http://mojha.unelgee.gov.mn/)-ний “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” хэсэгт байгууллагад хамаарах тайланг хугацаанд нь буюу 01 дүгээр сарын 05-ны өдөр тайлагнаж, баталгаажууллаа.

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-д саналыг 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01/152 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийн саналыг 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01/134 дүгээр, Хууль зүй, дотоод хэргийн салбарын “Хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөө”-д тусгах саналыг 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/166 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

“Дэлхийн Монголчууд-II”, “Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөөнд саналыг 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/167 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлэв.

2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц, сургалт:

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны тайлан, судалгааг 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/190 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.

Гүйцэтгэх албан тушаалын 6 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг 12 дугаар сарын 16-аас 20-ны хооронд нийтэд зарлан, тусгай шалгалтыг 27-ны өдөр зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 6 албан хаагчийг 6 сарын туршилтын хугацаагаар тус тус томиллоо. Мөн удирдах албан тушаалын 2 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг 01 дүгээр сарын 24-өөс 27-ны хооронд нийтэд зарлаж, тусгай шалгалтыг 28-ны өдөр зохион байгуулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан 01 дүгээр сарын 13-ны өдөр төрийн захиргааны албан тушаалд жинхэлж томилогдсон 4 албан хаагчийн тангараг өргүүлэх ёслолын ажиллагааг зохион байгууллаа.

Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн систем 2022 оны 01 дүгээр сараас эхлэн “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо”-ны шинэ хувилбарт шилжсэнтэй холбогдуулан төвийн нэгжийн 115 албан хаагчийн мэдээлэлд баяжилт хийсэн.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Элчин сайдын яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийн аюулаас хамгаалах яам, Ардын цагдаагийн их сургуультай хамтран зохион байгуулсан “Монгол улсын хилээр орох, гарах удирдлагын сургалт-2021” сэдэвт сургалтад 12 дугаар сарын 13-ны өдрөөс 16-ны өдрүүдэд 20 албан хаагч цахимаар хамрагдлаа.

Төрийн албаны зөвлөлийн сургалт судалгаа мэдээллийн нэгдсэн сангийн газраас 01 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан “Аз жаргалтай ажиллахын нууц” сэдэвт сургалтад Захиргаа, удирдлагын газрын дарга, хүний нөөцийн мэргэжилтнүүд, орон нутаг дахь нэгжийн захиргааны ахлах мэргэжилтнүүд цахимаар тус тус хамрагдсан.

“Ахлах нягтлан бодогчдын цугларалт”-ыг 01 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулж, цугларалтаар “Татварын хуулийн шинэчлэл, татварын тайлан гаргахад анхаарах асуудал”, “Мэргэжлийн ёс зүй, сахилга бат, хариуцлага”, “Сайн зан чанарын хөгжлөөр эерэг хандлага, харилцааг сайжруулах нь”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэглээ” сэдвүүдээр хичээл заав.

Мөн 01 дүгээр сарын 10-ны өдөр “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэглээнд анхаарах асуудал” сэдэвт сургалтад төвийн нэгжийн 31 албан хаагчийг танхимаар, орон нутаг дахь нэгжийн 10 албан хаагчийг цахимаар тус тус хамруулсан.

Тагнуулын ерөнхий газраас 12 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Нууцын албан хэрэг хөтлөлтийн бүртгэлийн систем”, “Төрийн болон албаны нууцын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” сургалтад байгууллагын нууц хариуцсан мэргэжилтэн цахимаар хамрагдлаа.

2.1.3. Олон нийт, хэвлэл мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын цахим хуудаст үйл ажиллагаатай холбоотой 18 мэдээ, мэдээллийг байршуулж, 48 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (2 телевиз, 2 сонин, 44 сайт)-ээр сурталчилсан.

Байгууллагын цахим хуудас (фейсбүүк, твийтэр), elmmigration аппликэйшнд баяжилтыг хийж, байгууллагын үйл ажиллагаа болон үйлчилгээ авахтай холбоотой нийт 48 мэдээллийг байршууллаа.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

2.2.1. Хууль, эрх зүй:

“Хүүхдийн мөнгөн хуримтлалыг төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох, түр журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд саналыг 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01/133 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

“Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-д орсон нэмэлт өөрчлөлтийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг 01 дүгээр сарын 05-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахимаар хүргүүлэв.

Байгууллагын даргын тушаалаар баталсан, байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан нийт 70 журмыг хянаж, холбогдох нэмэлт өөрчлөлтийг тусган, танилцуулга бэлтгэлээ.

2.2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Байгууллагын дарга 12 дугаар сарын 14-ний өдөр Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Жалгас Жумаевич Адилбаег хүлээн авч уулзлаа.

Тайпэйн Худалдаа, Эдийн засгийн төлөөлөгчийн газрын хоёрдугаар нарийн бичгийн дарга, холбогдох албаны хүмүүсийг 01 дүгээр сарын 06-ны өдөр Гадаад харилцааны хэлтсийн дарга хүлээн авч уулзан, гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

Бусад орны ижил чиг үүргийн байгууллагуудад өрнөж буй мэдээ, мэдээллийг “7 хоногийн тойм” нэрээр бэлтгэн албан хаагчид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэв.

2.3. Цар тахлын нөлөөллийг бууруулах, гамшиг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дотоод хяналтын чиглэлээр:

2.3.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх:

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан 01 дүгээр сарын 13-ны өдрийн 03/08 дугаар, 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/09 дугаар дотоод албан бичгээр Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед ажиллах чиглэлийг зохион байгуулалтын нэгжийн дарга нарт хүргүүлсэн.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд долоо хоног бүрийн Мягмар, Баасан гарагуудад өрөө тасалгаа, заал талбай, шат хонгилын ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийж байна.

2.3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх:

Байгууллагын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/100 дугаар, “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлт болон “2022 оны төлөвлөгөө”-д тусгах саналыг 01 дүгээр сарын 12-ны өдрийн 02/184 дүгээр, “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлт болон “2022 оны төлөвлөгөө”-д тусгах саналыг мөн өдрийн 02/185 дугаар, байгууллагын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-г 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/252 дугаар албан бичгээр тус тус Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанд хүргүүлэв.

2.3.3. Дотоод хяналт:

Тайлант хугацаанд байгууллагын удирдлагаас өгсөн үүргийн дагуу төлөвлөгөөт бус 6 шалгалтыг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”-д заасан хугацаанд явуулж, тухайн зөрчилтэй холбоотой шалгалтын материал, дүгнэлт, саналыг холбогдох албан тушаалтанд танилцуулан, шийдвэрлүүлсэн.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

2022 онд цахимд шилжүүлэх 2018-2020 оны 276 хадгаламжийн нэгжийн 53629 хуудас баримтын нэгдсэн бүртгэл үйлдсэн.

Хууль тогтоомжийн хүрээнд 129 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, бүртгэл хөтлөв.

Тайлант хугацаанд байгууллагын даргаас А тушаал 15, Б тушаал 26 буюу нийт тушаал баталсныг цахим хэлбэрт шилжүүлж, архив албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэн, хариуцсан албан хаагчдаар үүргийн биелэлтийг хангуулан ажиллаж байна.

Байгууллагад ирүүлсэн нийт 306 албан бичиг (хариутай 145)-ийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, нийт 275 албан бичгийг гадагш илгээсэн ба хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 3 албан бичиг, хяналтад 30 албан бичиг байна.

2.4.2. Өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, албан хаагчаас нийт 110 өргөдөл ирүүлснийг хүлээн авч, 98 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 12 өргөдөл шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

2.5.1. Программ хангамж:

“Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн хөгжүүлэлтийн хүрээнд системийн шаардлагын эцсийн хувилбарыг бэлтгэсэн.

Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем (RNSF)-д 120,070 гадаадын иргэнд 13 орон бүхий бүртгэлийн дугаар олгож, төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан үүрэн холбооны 4 оператор компанид хандах эрхийг үүсгэв.

“elmmigration.mn” системд оршин суух зөвшөөрлийн сунгалт болон хасалтын үйлчилгээг шинээр үүсгэж, 8 дэд ангиллын 50 төрлийн үйлчилгээг нэмж хөгжүүллээ.

Байгууллагын цахим сайтын нэмэлт хөгжүүлэлтээр “Хүний нөөц”, “Авлигын эсрэг үйл ажиллагаа” талбарт харгалзах мэдээллийг байршуулж, “Албан болон хувийн хэргээр оршин суух” хэсэг дэх “Оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлт гаргах” талбарын ангиллыг нэмсэн.

“Хуулийн сан” системд өөрчлөлтийг оруулж, серверийг шинээр бэлтгэлээ.

2.5.2. Тоног төхөөрөмж, сүлжээ, хэвлэл, эх бэлтгэл:

Тайлант хугацаанд нийт 24 удаагийн дуудлагыг хүлээн авч, техник, тоног төхөөрөмж, сүлжээ, принтерийн засвар үйлчилгээг үзүүлсэн.

Байгууллагын мэдээлэл технологийн инженерүүдийн дунд “Info share” нэртэйгээр “Мэдээллийн цаг” арга хэмжээг эхлүүлж, долоо хоногт 2 удаагийн давтамжтайгаар төлөвлөн, эхний сургалтыг 01 дүгээр сарын 28-ны өдөр “NoSQL, MongoDB ажиллагаа” сэдвээр зохион байгууллаа.

Тайлант хугацаанд 2022 оны цаг тооны бичиг 180, ажлын үнэмлэх 271, утасны жагсаалт 50, нэрийн хуудас 80, маягтууд 350, А4 хэвлэл 186 хувь тус тус хэвлэж, байгууллагын албан хаагчдын компьютерын дэлгэцийн background, lock screen ашиглах зургийг бэлтгэж, хүргэсэн.

2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

2022 оны 01 дүгээр сард 1,642.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 482.5 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлж ажиллалаа.

Төсвийн шууд захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/259, 01/260 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яам болон Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn сайтад төв болон орон нутаг дахь газар, хэлтэс тухай бүрийн 48, сар бүрийн 24, улирал бүрийн 8, жилийн эцсээр 32 нийт 112 мэдээг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

Голомт банкны 1320000052 тоот төгрөгийн дансанд улсын тэмдэгтийн хураамжийн орлого болох 62.1 сая төгрөг, 130512499 тоот долларын дансанд улсын тэмдэгтийн хураамжийн орлого болох 1514.27 долларын орлогыг тус тус төвлөрүүлээд байна.

2.6.3. Худалдан авалт:

Багаж техник хэрэгсэл, Мэдээлэл технологийн үйлчилгээ, Нормын хувцас, Шатахуун нийлүүлэгч сонгон шалгаруулах нээлттэй тендерийг www.etender.gov.mn сайтад байршуулж тус тус зарласан.

Баруун бүс дэх газрын үйлчилгээний цогцолбор барилгын тендерийг 01 дүгээр сарын 20-ны өдөр зарлалаа.

2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

2.7.1. Хяналт-шинжилгээ:

Байгууллагын үйл ажиллагааны 12 дугаар сарын тайлан, 2021 оны үйл ажиллагааны тайлан, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын 2021 оны 4 дүгээр улирлын танилцуулах тойм мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, дотоод аудитын газарт 2021 оны 01/93, 01/94, 01/95, 01/96 дугаар, Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугч, цагаач, харьяалалгүй хүний талаарх судалгаа, танилцуулах тойм мэдээг 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/97 дугаар, Үндэсний аюулгүй байдлыг

хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын хамтран хэрэгжүүлэх 2021 оны нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/205 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд, Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэдийн 2021 оны жилийн эцсийн мэдээг 01 дүгээр сарын 05-ны өдөр Үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлэв.

Байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд “Хөгжлийн санаачилга бодлого судлалын төв” төрийн бус байгууллагаас явуулсан хэрэглэгчийн үнэлгээний ажил болон албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгааны ажлын 93,75 буюу 4,67 оноогоор дүгнэгдсэн тайланг хүлээн авлаа.

Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийн, үнэлгээ өгч 12 дугаар сарын 14-ний өдөр Даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 97,16 хувь, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн байгууллагад холбогдох арга хэмжээний 2021 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг 100 хувь, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийг 97,12 хувиар тус тус үнэлж, хяналт-шинжилгээний тайланг боловсрууллаа.

Зохион байгуулалтын нэгжийн дарга нарын 2021 оны гүйцэтгэлийн тайлан, 2021 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг холбогдох албан тушаалтнуудад танилцуулав.

Байгууллагын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хэрэглэгчийн үнэлгээний тайланд ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын 2022 оны сургалтын төлөвлөгөөнд тус тус хяналт-шинжилгээ хийж 01 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд холбогдох нэгжид хүргүүлсэн.

2.7.2. Аудит, нийцлийн чиглэлээр:

Байгууллагын дотоод аудитын чиглэлээр 2021 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг 2021 оны 03/23 дугаар, Шилэн дансны тухай хуулийн 2021 оны хэрэгжилтэд аудит хийсэн тайланг 2022 оны 03/221 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

Байгууллагын даргын 2022 оны “Шилэн дансны тухай хуулийн 2021 оны 4 дүгээр улирлын хэрэгжилтэд дотоод аудит хийх тухай” 01-10/01 дүгээр удирдамжийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Орон нутаг дахь нэгжүүд 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу дотооддоо 4 удаагийн сургалт зохион байгуулж, бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 170 албан хаагч хамрагджээ.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сэлэнгэ аймагт байрлах Сүхбаатар хилийн боомтод баригдаж байгаа хилийн хяналтын байгууллагуудын нэг цэгийн

үйлчилгээний цогцолборын 6 давхар барилгын ажлын явцын гүйцэтгэл 95,0 хувьтай байна.

Баруун бүс дэх газар Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын газар, Хилийн 0130, 0245, 0311, 0214, 0277 дугаар ангитай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөг тодотгов.

Дорноговь аймаг дахь газар Хилийн 0108, 0168 дугаар ангитай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөө, Хилийн Замын-Үүд боомтод мөрдөх тусгай журам, хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тус тус баталлаа.

Зүүн бүс дэх газар Эрээнцав, Ульхан боомт дахь албан хаагчийн амьдрах байранд урсгал засвар хийж, Хавирга, Баянхошуу, Бичигт, Эрээнцав, Ульхан боомтын албан өрөөнд хяналтын камер тус тус суурилуулсан байна.

--oo0oo--